



ЗӨВЛӨМЖ

#1. ЗӨВЛӨМЖ

Авлигатай тэмцэх газрын 2018 оны 4 дүгээр сарын 30-ны зөвлөмжид дурдсан зөрчил, дутагдал дахин гарч байгаад дүгнэлт хийх, таслан зогсоох.

Нэг. Сангийн сайдын 2012 оны 239 дугаар тушаалаар баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.3-т "энэ журмын 2.1.1, 2.1.2 дахь хэсэгт заасан хохирлыг арилгахтай холбогдсон арга хэмжээг санхүүжүүлэхэд зориулж **нийт батлагдсан хөрөнгийн 30-аас доошгүй хувийг Зас аг даргын нөөцөд байлгана**" гэж заасныг хэрэгжүүлэхгүй байна. Тухайлбал, 2018.11.16-ны өдрийн байдлаар Өвөрхангай аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн үлдэгдэл 7 193 300 төгрөг, Уянга сумын Засаг даргын нөөц хөрөнгийн үлдэгдэл 2 468 359 төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь батлагдсан хөрөнгийн 30%-д хүрэхгүй байна. Аймгийн Засаг дарга 2017 онд батлагдсан хөрөнгийн 10%, 2018 онд батлагдсан хөрөнгийн 7%, Уянга сумын Засаг дарга 2017 онд батлагдсан хөрөнгийн 29%, 2018 онд батлагдсан хөрөнгийн 43%-ийг цагаан сар, наадам, ой тэмдэглэх, тэмцээн уралдаан, мэндчилгээ дэвшүүлэхэд зарцуулжээ.

Хоёр. Баруунбаян-Улаан сумын ерөнхий боловсролын сургуулийн сургалтын менежер Б.Пүрэвдорж нь тухайн албан тушаалд томилогдсноосоо хойш 30 хоногийн дотор ХАСХОМ гаргаагүй, хугацаа хожимдуулж мэдүүлсэн зөрчил илэрсэн тул Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.1-т заасны дагуу хариуцлага тооцуулав.



Засгийн газрын 2011 оны 199 дүгээр тогтоолоор баталсан “Тэмдэгтийн хураамжийн хувь, хэмжээ”-ний 23.1.3-т аймаг, нийслэлийн Засаг даргаас ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг байгуулах зөвшөөрөл олгоход 250 000 төгрөгийн тэмдэгтийн хураамж авахаар тогтоосон. Гэтэл аймгийн хэмжээнд ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгт тусгай зөвшөөрөл олгох, сунгахдаа тэмдэгтийн хураамжийг төсөвт төвлөрүүлж байгаагүй. Аймгийн хэмжээнд 2017 онд хувийн хэвшлийн 2, төрийн 1 цэцэрлэгийн тусгай зөвшөөрлийг сунгасан бол 2018 онд 2 тусгай зөвшөөрөл шинээр олгож (төрийн цэцэрлэг, 1 нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн), 4 бага сургуулийн зөвшөөрлийг сунгасан.

Тус аймаг 2017 оны төгсгөл хүртэл “эрүүл мэндийн байгууллага мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх” тусгай зөвшөөрлийг олгохдоо тэмдэгтийн хураамжийг авдаггүй байсан бол 2017 оны 11 сараас эхлэн авах болсон. Улсын тэмдэгтийн хураамж гэж 23 байгууллагаас аймгийн Эрүүл мэндийн газрын Эмнэлгийн тусламжийн хэлтсийн дарга, тусгай зөвшөөрөл, чанар магадлан итгэмжлэл хариуцдаг Ю.Ичинноров бэлнээр мөнгө хураан авсан байв. Тэрээр бэлэн мөнгөний ордер бичиж, гарын үсэг зуруулан 4 115 000 төгрөг хураан авсны 3 000 000 (10000*75, 5000*42, 20000*102) төгрөгийг өөртөө хадгалж, 554 000 төгрөгийг эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох аймгийн Засаг даргын дэргэдэх комиссын гишүүдийн хурлын урамшуулал, хоолонд зарцуулсан, 1 115 000 төгрөгийг хэрхэн зарцуулагдсан нь тодорхойгүй байв. Түүнчлэн зарим тусгай зөвшөөрөл эзэмшигчээс улсын тэмдэгтийн хураамжийг аваагүй байсан.

#2. ЗӨВЛӨМЖ

Хууль болон эрх бүхий байгууллагаас тогтоосон хувь хэмжээгээр улсын тэмдэгтийн хураамжийг орон нутгийн төсөвт бүрэн төвлөрүүлэх, түүнд тавих хяналтыг чангатгах.



#3. ЗӨВЛӨМЖ

Өвөрхангай аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 2 дугаар тогтоолоор баталсан “Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын журам”, Уянга сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 07/03 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болгох

Хууль тогтоомжоор тусгайлан эрх олгоогүй байхад аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 2 дугаар тогтоолоор "Аймгийн ИТХ-ын даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын журам"-ыг батлан мөрдүүлсэн ба 2018 онд 28 500 000 төгрөг төсөвлөж, 23 576 250 төгрөгийг зарцуулжээ. Уг хөрөнгийг гадны зочид төлөөлөгчдийн хоол, буудал, унаа, бэлэг, хууль тогтоомжид зааснаас бусад нэг удаагийн тэтгэм, шагнал, урамшуулал, уралдаан тэмцээн хуулиар олгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбоотой цаг үеийн шинжтэй арга хэмжээнд зарцуулахаар журамласан.

Уянга сумын сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 3 дугаар сарын 28-ны өдрийн 07/03 тогтоолоор батлагдсан хөрөнгийн 25%-ийг тээвэр шатахууны зардалд, 15%-ийг эд хогшил, тоног төхөөрөмж, урсгал зардалд, 15%-ийг нь иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын зардалд, 20%-ийг нь уралдаан тэмцээн, шагнал урамшууллын зардалд, 25%-ийг нь автомашины сэлбэг, эд ангийн зардалд зарцуулахаар тогтоосон. Тус сум 2018 онд тус нөөцөд 5 000 000 төгрөг баталж, шатахуун, шагнал, эд хогшлийн зардалд 3 944 500₮-ийг зарцуулсан.



Уянга сумын төрийн сан дахь Сум хөгжүүлэх сангийн дансанд мал хамгаалах сан, байгаль орчныг хамгаалах сан, ахмадын сан, урлаг соёлын сангийн хөрөнгийг байршуулсан нь Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолоор баталсан "Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам"-ын 1.4-д заасан буюу **тус сангийн хөрөнгөөс бусад хөрөнгө уг дансанд байршуулахыг хориглосон** зохицуулалтыг зөрчсөн.

Төсөл хүлээн авах, сонгон шалгаруулах зарыг олон нийтэд хүргэхдээ сумын Засаг даргын Тамгын газрын [facebook](#) хаяг (иргэдэд нээлттэй байдаг гэх)-аар хүргүүлсэн, төрийн байгууллагуудын үүдэн дэх мэдээллийн самбарт байршуулсан гэх боловч энэ нь иргэдэд тэр бүр хүрдэггүй, ЗДТГ-ын албан хаагчид, төсөл сонгон шалгаруулах зөвлөл, хяналтын зөвлөлийн гишүүдийн эргэн тойронд мэдээлэгдэж байна гэж үзэхээр байна. Тухайлбал, 2017 онд төсөл сонгон шалгаруулах зөвлөлийн гишүүн Г.Батжаргал (5 сая төгрөг), З.Болортуяагийн хамаатан гэх Д.Ханбүргэд (8 сая төгрөг), 2018 онд зөвлөлийн гишүүн Г.Болдбаатарын төрсөн эгч Т.Бэлэгт (5 сая төгрөг), зөвлөлийн гишүүн Р.Батгэрэл (20 сая төгрөг) нар зээл авсан.

#4. ЗӨВЛӨМЖ

Сум хөгжүүлэх сангийн дансанд бусад эх үүсвэр бүхий хөрөнгийг байршуулахгүй байх, зээл олгох төсөл, арга хэмжээг хүлээн авах, сонгон шалгаруулах зарыг ил тод хүргэх талаар зохион байгуулалтын арга хэмжээ авах

**#5. ЗӨВЛӨМЖ**

Нийтийн албан тушаалтанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиар хориглосон, хязгаарласан хэм хэмжээг зөрчихгүй байх, энэ талаар нийтийн албан тушаалтнуудад зориулсан сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэгт “албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно” гэж заасан.

Гэтэл Өвөрхангай аймгийн Уянга сумын Жаргалант багийн сургуулийн захирал О.Мөнхтуяа нь 2014 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн Б/15 тушаалаар төрсөн хүү Ч.Ариунбаатарын дотуур байрны багшаар, мөн өдрийн Б/12 тушаалаар хүү Ч.Ариунбаатарын эхнэр Т.Энхчимэгийг түүх, нийгмийн ухааны багшаар тус тус томилсон байна. Түүнчлэн тус сургуульд математикийн багшаар ажиллаж байгаа төрсөн охин Ч.Нямсүрэн (өмнөх захирлын тушаалаар томилогдсон) болон, төрсөн хүү Ч.Ариунбаатар, бэр Энхчимэг нарт үр дүнгийн урамшуулал, говийн урамшуулал олгохдоо хуульд заасан мэдэгдэл, тайлбарыг гаргаагүй. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.4 дэх хэсэгт заасны дагуу О.Мөнхтуяад хариуцлага тооцуулаад байна.



Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөө бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.9-д зааснаар захиалагч нь “гүйцэтгэгч компанийн товч танилцуулга, харилцах утас, гүйцэтгэж байгаа ажил, үйлчилгээний гэрээний үнийн дүн, санхүүжилтийн хуваарь, ажил эхлэх, дуусах хугацаа болон авто зам, инженерийн шугам сүлжээний хувьд дайран өнгөрөх маршрут зэргийг багтаасан мэдээллийн самбарыг төв, суурин бүрийн олон нийтэд үзэгдэхүйц газар уг ажил, үйлчилгээний баталгаат хугацааны туршид заавал байрлуулахыг шаардах” эрхтэй. Тус аймгийн хэмжээнд 2018 онд улсын болон орон нутгийн төсөв, орон нутгийн хөгжлийн сан, замын сангийн хөрөнгө, байгууллагын захиалгаар нийт 70 төсөл, хөтөлбөр, арга хэмжээ хэрэгжихээс 66 төсөл арга хэмжээг (2018.11.05-ны байдлаар) хэрэгжүүлсэн. Гэтэл эдгээр төсөл, арга хэмжээний гүйцэтгэгч нар хуульд заасан дээрх мэдээлэл бүхий самбарыг олон нийтэд харагдахуйц газар байршуулаагүй байсан.

#6. ЗӨВЛӨМЖ

Худалдан авах ажиллагааны гүйцэтгэлийн явцад иргэн, иргэний нийгмийн байгууллага, сонирхогч этгээдээс хяналт тавих боломжийг олгох, ил тод нээлттэй байдлыг хангах.

#7. ЗӨВЛӨМЖ

Үнэлгээний хорооны үйл ажиллагаа, үнэлгээний дүгнэлт хууль тогтоомжид нийцсэн эсэхэд тавих хяналтыг чангатгах, гарсан зөрчлийг тухай бүр арилгуулах.

Тус аймгаас зохион байгуулсан тендер шалгаруулалтын үйл ажиллагаатай холбоотой 2017 онд 2, 2018 онд 11 (3 дугаар улирлын байдлаар), нийт 13 гомдлыг Сангийн яамнаас шалган үзээд 7 (2017 онд 2, 2018 онд 5)-г нь “захиалагчийн шийдвэрт гаргасан гомдол нь үндэслэлтэй” гэж үзсэн. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай 46 дугаар зүйлийн 46.1.2-д заасан захиалагч бараа, ажил, үйлчилгээг худалдан авах талаар үнэлгээний хорооны үйл ажиллагаа, үнэлгээний дүгнэлт холбогдох хууль тогтоомжид нийцсэн эсэхэд хяналт тавьж, гарсан зөрчлийг арилгуулах эрх, үүргээ хэрэгжүүлж ажиллахад анхаарах шаардлагатайг харуулж байна.



#8. ЗӨВЛӨМЖ

Авлигатай тэмцэх газрын даргын 2018 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн А/123 дугаар тушаалаар баталсан “Албан тушаалтан өөрт ногдуулсан сахилгын шийтгэлийн талаарх мэдээллийг холбогдох этгээд болон нийтэд өөрийн зардлаар хүргэх арга хэмжээний журам”-ыг хэрэгжүүлэх, журмын 4.1-д заасан хугацаанд холбогдох мэдээллийг ирүүлж хэвших.

Захиргааны ерөнхий хуулийн шаардлагад нийцүүлэн “Албан тушаалтан өөрт ногдуулсан сахилгын шийтгэлийн талаарх мэдээллийг холбогдох этгээд болон нийтэд өөрийн зардлаар хүргэх арга хэмжээний журам”-ыг шинэчлэн боловсруулж, Авлигатай тэмцэх газрын даргын 2018 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн А/123 дугаар тушаалаар баталсан бөгөөд уг журам нь захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 2018 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 4036 дугаартай бүртгэгдсэн (журмыг <https://www.legalinfo.mn/law/details/13778?lawid=13778> -ээс татаж үзэх).

Журмын 4.1-т “Албан тушаалтанд сахилгын шийтгэл ногдуулсан талаарх мэдээллийг холбогдох этгээдэд хүргэсэн болон нийтэд мэдээлсэн өдрөөс хойш ажлын 5 өдрийн дотор журмын 2.1, 3.1-т заасан мэдээллийг тухайн албан тушаалтанд сахилгын шийтгэл ногдуулсан шийдвэр (хуулбар)-ын хамт эсхүл холбогдох мэдээллийг цахим хэлбэрээр Авлигатай тэмцэх газарт ирүүлнэ.” гэж заасан.